

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ



1999 оны 7 дугаар
сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ

(хэсэгчлэн авав)

25 дугаар зүйл. Тагнуулын ажилтанд үзүүлэх хөнгөлөлт, нөхөн төлбөр

25.1. Улсын хил дээр ажиллаж байгаа тагнуулын ажилтанд Хилийн тухай хуулийн 36.4, 36.6-д заасан нь нэгэн адил хамаарна.

25.5. Байгууллагынхаа шийдвэрээр өөр газарт шилжин ажиллах болсноос түүний эхнэр /нөхөр/ нь эрхэлж буй ажил, хөдөлмөрийн гэрээгээ цуцлахад хүрвэл түүнд тагнуулын ажилтны нэг сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тагнуулын байгууллага олгоно.

25.7. Гадаадын тусгай алба, байгууллага, гэмт бүлэглэлд нэвтрэн тусгай үүрэг гүйцэтгэсэн болон ажиглалтын албанд ажилласан нэг жилийг 1 жил 4 сартай дүйцүүлэн тооцно.

26 дугаар зүйл. Тагнуулын ажилтны тэтгэвэр, тэтгэмж, тусламж

26.1. Тагнуулын ажилтны тэтгэмжийн харилцааг цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

Р.ГОНЧИГДОРЖ